



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/15.

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны "Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг батлах тухай" 13/53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.8.-ын "Найрсаг Улаанбаатар" аялал жуулчлал, соёл урлагийн хөтөлбөр боловсруулах дэд зорилтын хүрээнд 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хөтөлбөрийн төслийг аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийнхэнд танилцуулах уулзалтыг зохион байгуулах ажлыг ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасгай.


2. "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн төслийг аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхэнд танилцуулах уулзалтад шаардагдах 468,440 /Дөрвөн зуун жаран найман мянга дөрвөн зуун дөч/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн
А/5 дугаар тушаалын хавсралт



"Найрсаг Улаанбаатар" уулзалтыг зохион байгуулахад
шаардагдах зардлын жагсаалт

Д/д	Ажлын нэр	Гүйцэтгэл /тоо, ширхэг/	Нэгж үнэ	Нийт үнэ
1	"Найрсаг Улаанбаатар" хулдаасан хэвлэл /4x2,3 x 2хувь/	18,4м ²	6,600₮	121,440₮
2	Стэнд	2 ширхэг	38,500₮	77,000₮
3	"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн танилцуулгын эх бэлтгэл	1 ширхэг	15,000₮	15,000₮
4	"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн танилцуулгыг хэвлүүлэх	75 ширхэг	3400₮	255,000₮
НИЙТ ДҮН: 468,440 ₮				

Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн

Хянасан: Ахлах нягтлан бодогч

Г.Баясгалан

П.Ариунаа